

Хөрөнгө оруулагчийн итгэлийг сэргээхэд хувь нэмэр оруулж буй МОНГЕОКАТ СИСТЕМ

Канад Улсын Фрэйзеринститут дэлхийн улс орнуудыг уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт татах чадвараар нь жил бүр эрэмбэлдэг бөгөөд ингэхдээ харгалзан үздэг арав гаруй үзүүлэлтийн нэг нь тухайн орны геологи, хайгуулын мэдээллийн нээлттэй байдал байдаг. Товчхондоо хөрөнгө оруулагчид тухайн улсад очоод геологи, хайгуулын мэдээлэл авах үйл явц ямар байдгийг тандсан үзүүлэлт гэж ойлгож болно. Манай улс энэ үзүүлэлтээр 2016 онд 36 хувийн үнэлгээ авсан бол өнгөрсөн жил 75 хувь болон өсчээ. Энэ үзүүлэлт оцлом өсөхөд Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газар хамтран Австрали улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хөгжүүлсэн геологийн мэдээллийн хайлттын каталоги систем, товчилбол Монгеокат систем хувь нэмэр оруулсан гэж үзэж болохоор байна.

Монгол Улс жилд 6.2 тэрбум ам.доллар олдог, үүний зургаан тэрбум дол-

нирхолтой бизнесмэн хаа байгаа Африкаас компьютерийнхаа ард сууж байгаад хүссэнээ харчих нөхцөлийг Австраличууд аль хэдийнэ бүрдүүлжээ. Тийм ч учраас уул уурхайн салбарт нь хайгуул идэвхтэй өрнөж, том төсөл хөтөлбөр хэрэгжиж, уул уурхайгаас олсон мөнгө эдийн засгийг нь тэтгэж буй. Уул уурхайгаас олсон мөнгөөрөө бусад салбараа сэвийтлэл босгож ирсэн улсын нэг гэдгийг нь дэлхий даяараа жишээлэн ярьдаг.

Манай улс хараахан Австралийн жишигт хүрээгүй ч хөрөнгө оруулагчдад геологийн мэдээллээ нээлттэй байлгах, алсдаа хайгуулд их хэмжээний хөрөнгө, мөнгө татах сууриа тавиад байна. Тэр нь нийтлэлийн эхэнд дурдсан Монгеокат систем.

Бүр тодруулж хэлбэл ирээдүйд хөгжих мөнгөө уул уурхайгаасаа босгоё гэж байгаа л бол геологи хайгуулын ажлын мэдээллийг цахимжуулахаас өөр сонголтгүй гэдгийг олж хараад эхлүүлсэн ажил.

АМТГГ-ын Эрдэс баял-

сайтад нэвтрээд англи, монгол хэлээр харах боломж бүрдсэн байна. Өмнө нь эдгээр тайланг үзэх гэж тус байгууллагыг зорьж очоод, хайж буй мэдээллээ газрын зураг дээр багцаалж, хэд хэдэн тайланг захиран аваад, тэр дундаас өөрт хэрэгтэй материалаа хайж олдог байсныг бодоход шинэ үсрэлт, дэвшилт мөн үү гэвэл мөн. Ямартай ч хөрөнгө оруулагчид хайгуул хийх шийдвэр гаргахын тулд ашигладаг анхан шатны мэдээллийг компьютерийнхаа ард суугаад авчигдаж болж. Гэхдээ хөрөнгө оруулагчдад илүү гүнзгий, дэлгэрэнгүй мэдээлэл хэрэгтэй. Жишээ нь зэсийн салбарт хөрөнгө оруулалт хийх сонирхолтой хүн геологийн анхдагч мэдээллийг өөрийн хүсэж байгаа хэлбэрээр татан авч ашиглахыг сонирхоно. Одоохондоо ийм нарийн мэдээллийг цахимаар авах боломж хараахан бүрдээгүй байна. АМТГГ-ын Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн архивт хөрөнгө оруулагчдын хүсээл

буйг Монгеокат-ын гүйцэтгэлээс харчихаж болно. Монгеокат систем нь олон улсад нэр хүндтэй Дэлхийн гео орон зайн форумаас энэ жилийн дэлхийн геологийн шилдэг бүтээлээр шалгарчээ. Хэр чанартай ажил болсны тод жишээ л дээ. Монгеокат хэр эрэлт хэрэгцээтэй ажил болсныг тус системээр үйлчлүүлсэн 39 орны 30 мянган хандалтаас харчихаж болно. Тэдний 30 хувь нь тус системийг тогтмол хэрэглэдэг гэсэн статистик гарчээ. Гадаад, дотоодын олон хэрэглэгчид "Монгеокат"-д ам сайтай байна. Тэдний нэг олон улсын хайгуулын компанид ажилладаг нэгэн геологичоос "Монгеокат системээс амар мэдээлэл авч юунд ашигласан бэ" гэж асуухад "Хоёр зорилгоор ашигласан. Нэгдүгээрт ямар газарзүйн мэдээлэл буюу геологи, геофизик, геохими болон лицензүүдийн тухай мэдээлэл тус санд байгааг харах гэж, хоёрдугаарт, тухайн лицензэд холбогдох мэдээллийн хүсээл

нь багасаад амар болно. Эцэст нь хэлэхэд надад их таалагдсан. Монголыг гадаад ертөнцтэй холбоход дөхөм үзүүлсэн систем болсон" гэсэн хариу өгсөн юм. Монголын геологичдоод ч Монгеокат өгөөжөө өгөөд эхэлснийг батлах тодорхой жишээ байна.

Хөрөнгө оруулагчид ямар ч улсад хөрөнгө оруулахдаа хууль эрх зүйн орчин гэх мэт олон хүчин зүйлийг харгалзан үздэг. Дэлхийн улс орнуудын том хөрөнгө оруулагчид Монголын хувьд уул уурхайн салбарт хөрөнгө оруулах сонирхол түлхүү байдаг. Энэ утгаараа Монгол Улсын хөрөнгө оруулалт их хэмжээгээр татах боломжтой салбар нь уул уурхай. Уул уурхайн салбараа томгоё, хөгжүүлэе гэвэл эхлээд геологи хайгуулыг дэмжихээс аргагүй. Геологи хайгуулыг дэмжинэ гэдэг нь геологийн мэдээллийг хөрөнгө оруулагчдад хүргэх ажлаас эхэлнэ. Тухайн хөрөнгө оруулагч Монголд ирэх шаардлагагүйгээр

тэрбум ам.доллар олдог, үүний зургаан тэрбум долларыг уул уурхайн бүтээгдэхүүн зарж, үлдэж буй 200 сая ам.долларыг нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болон бусад бүтээгдэхүүний борлуулалтаас олдог гэсэн статистикийг "Өдрийн сонин"-ы саяхны дугаарын нийтлэлд онцолжээ. Тус нийтлэлд уул уурхайгаас олох мөнгөө өнөөдрийнхөө огцом өсгөх шаардлагатай, тэгж чадвал Чили шиг байхгүй загасаа хүртэл бий болгоод тэрбум ам.долларыг дэлхийн зах зээлээс шүүрдэх боломжтой гэсэн сонирхолтой дүгнэлт хийсэн

мүүс геологийн мэдээлэл авахын тулд Улаанбаатарыг зорин ирж байна. Тэд Геологийн төв архив дээр дугаарлаж, зузаан тайлангуудыг цаасаар нь авч үзэж танилцаад, буцааж хуудас хуудсаар нь тоолж хүлээлгэн өгдөг. Дэлхийн нүдээр харвал хэтэрхий болхи тогтолцоо л доо. Бидний жишээ татаж ярих дуртай Австрали Улсын Геологийн албаны вэб сайт руу орлоо л бол бүгдийг үзэх боломжтой. Зарим нэг төлбөрт үйлчилгээг эс тооцвол төлбөргүйгээр ашиглаж болох мэдээлэл тоймгүй. Зэсийн салбарт нь хөрөнгө оруулах со-

сонголтгүй гэдгийг олж харгаад эхлүүлсэн ажил. АМТГ-ын Эрдэс баалгийн мэдээллийн технологийн төв нь Монголын хаана ямар эрдэс байгааг байгааг судалсан мэдээллийг цуглуулдаг, цуглуулсан мэдээллээ хадгалж, баяжуулж хэрэглэгчдэд мэдээллээр үйлчлэх чигээр ажилладаг. Дээр дурдсанчлан тэд хэрэглэгчдэд мэдээллээр үйлчлэхдээ Монгеокат системийг ашиглаж байна гэсэн үг. Өнөөдрийн байдлаар хамгийн түгээмэл хэрэглэдэг 2,000 орчим геологийн тайлангийн хураангуй <https://mgram.gov.mn/>

баялгийн мэдээллийн технологийн төвийн архивт хөрөнгө оруулагчдын хүсээд буй нарийн мэдээллүүд цаасан хэлбэрээрээ байдаг ч одоохондоо цахим хэлбэрт хараахан шилжээгүй. УУХУЯ, АМТГ-ын зүгээс геологи, хайгуулын ажлын төрөл бүрийн нарийн мэдээллийг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Мэдээж цаг хугацаа, санхүүжилт шаардсан, процесс дамжлага ихтэй ажил байх нь тодорхой. Гэхдээ зориод хийхэд харьцангуй бага хугацаанд амжуулах нөөц боломж аль аль талд нь

гэж, хоёрдугаарт: тухайн лиценцэд холбогдох мэдээллийн хүрээг мэдэж, хаягаар нь хандан мэдээллийг худалдан авч, өөрт байгаа мэдээлэлтэй давхцуулж харах боломжтой эсэхийг мэдэх зорилгоор ашигласан. Миний зүгээс хэлэх нэг санал байна. Бэлдсэн төрөл бүрийн давхаргуудаа WFS буюу цахим хуудсанд суурилсан үйлчилгээг хэрэглэгчиддээ олгоод, өөр өөрийн хэрэглэж буй компьютер, программ дээрээ шууд тааад ажиллаж болдог болгох хэрэгтэй байна. Ингэвэл цаг хугацаа болон нэмэлт ажил зарцуулах

рөнгө оруулагч Монголд ирэх шаардлагагүйгээр манай улсын геологийн мэдээллийн нэгдсэн сангаас сонирхол татахуйц талбайд хийгдсэн эрдэм шинжилгээ болон улсын компанийн тайланг үзэж, судлах нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байгаа. Эхний ээлжинд геологи, ашигт малтмалын мэдээллээс гадна геофизик, геохими, гидрогеологийн анхдагч мэдээллийг авах боломжийг бүрдүүлбэл, эдийн засагт шууд бус байдлаар эерэг нөлөө үзүүлэх боломжтой гэсэн дүгнэлт байна.

П.БАЯР